

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮН**

2026.06.23

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний холбогдох стратегийн зорилгуудын хүрээний 12 зорилтын 28 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Тус газрын гүйцэтгэлийн тайланг "Журам батлах тухай" Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.4, 2.5-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хүрэх түвшин нь 01-12 сар (жилийн) болж заасан арга хэмжээг хагас жилийн байдлаар үнэлэхдээ зорилтот түвшинг 50%-иар хуваан авч, гүйцэтгэлтэй харьцуулан тооцоо.

Гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ холбогдох аргачлалын дагуу батлагдсан төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тус тус харгалзан үзсэн.

Хүснэгт-1

№	Төлөвлөлтийн хэсэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь /өөрсдийн үнэлсэн/	Үнэлгээ
1	Зорилт 1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны арга хэмжээний төлөвлөгөө"-г баталж, хэрэгжилтийг хангуулах	1	4	100%	100%
2	Зорилт 2. Төрийн албаны шинэчлэлийн хүрээний байгууллагын гүйцэтгэлийн болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээний журмыг шинэчлэх	1	2	40%	80%
3	Зорилт 3. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайдын захирамж, албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж, мэргэшил арга зүйгаар хангах, үр дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулах	1	9	100%	91.7%
4	Зорилт 4. Иргэн, хуулийн этгээдээс Засгийн газар, Ерөнхий сайдад хандаж гаргасан өргөдөл, гомдлын	1	1	100%	100%

	шийдвэрлэлтийн тайлан мэдээг нэгтгэн, арга хэмжээний санал, шийдвэрийн төслийг боловсруулах				
5	Зорилт 5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээлэлд тулгуурлан технологийн дэвшлийг ашиглан мэдээллийг боловсруулж, бодлогын шийдвэр гаргалтад ашиглах	1	1	100%	85%
6	Зорилт 6. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний тайланг нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	1	3	100%	91.7%
7	Зорилт 7. ЗГХЭГ-ын даргын төсвийн багцын байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, удирдлагыг мэдээллээр хангах	1	2	85%	85%
8	Зорилт 8. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллага, төрийн өмчийн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх	1	1	100%	85%
9	Зорилт 9. ЗГ-ын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийг уялдаа, удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	1	1	100%	90%
10	Зорилт 10. ЗГХЭГ-ын даргын шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг холбогдох хугацаанд тухай бүр тайлагнаж удирдлагад танилцуулах	1	2	100%	85%
11	Зорилт 11. Засгийн газрын тогтоол, шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль тогтоомж, шийдвэрийн төсөлд хууль зүйн мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх	1	1	100%	85%
12	Зорилт 12. Иргэн, хуулийн этгээд, төрийн бусад байгууллагаас Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын удирдлагад хандаж ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, хуульд заасан хугацаанд хариу өгч, шийдвэрлэх	1	1	100%	90%
	Дундаж ерөнхий үнэлгээ	12	28	93.8%	89%

Хүснэгт-2

Газар, хэлтэс	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	85 буюу түүнээс дээш хувь бол "бүрэн хангалттай" (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшинд нь хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд нь бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн)	70-85 хүртэл хувь бол "хангалттай" (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд нь бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах)	70 хүртэл хувь бол "хангалтгүй" (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотолгоотой.)
ХШУДАГ	12	28	24	4	0

ДҮГНЭЛТ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг **93.8%** хувиар үнэлж ирүүлснийг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж **89%** хувиар үнэлэв. Үнэлгээнд хамарсан 12 зорилтоос "бүрэн хангалттай" ($\geq 85\%$) — 11 зорилт, "хангалттай" (70-85%) — 1 зорилт, "хангалтгүй" ($< 70\%$) — 0 зорилт тус тус авсан.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2026 оны эхний хагас жилд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас онцолбол:

- 1348 шийдвэрийн 5688 заалтын хэрэгжилтэд ХШҮ хийж, нэгдсэн дүнг ЗГ-ын 07, 15, 17, 18, 20 дугаар хуралдаанд хэлэлцүүлж, 73.98%-ийн хэрэгжилт нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.9%-иар өссөн.
- 1111 шийдвэрийн 3412 заалтыг хяналтаас хасах үндэслэлтэй гэж тогтоож, Ажлын хэсэг байгуулан 2026.06.10-нд цахим санг шинэчлэн нээсэн.
- МУШС-ын 2023-2026 оны санхүүгийн аудитаар 1,062.1 сая ₮-ийн 17 зөрчил, ЗГБНҮГ-ын аудитаар 1,307.6 сая ₮-ийн 10 зөрчил илрүүлж, зөвлөмж хүргүүлсэн.
- МЕРИТ төслийн хүрээний бүсийн 5 аймагт ХШҮ-ний чадавхыг бэхжүүлэх сургалт зохион байгуулсан.
- 2026.03.25-ны 23 дугаар тушаалаар яам, аймаг, нийслэлийн 2026 оны онцлох ажлыг дүгнэх журмыг батлуулсан.
- ЗГ-ын хуралдааны журмын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж 72.5%-ийн хэрэгжилт тогтоон, 4 дүгнэлт, 11 зөвлөмж гаргасан.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс анхаарах шаардлагатай ажлаас дурдвал:

- Зорилт 2 (80%): ЗГ-ын болон ТЗАХ-ийн гүйцэтгэлийн үнэлгээний журмыг шинэчлэх ажлыг хуулийн шинэчлэлтэй уялдуулан хоёрдугаар хагас жилд эрчимжүүлэх.
- Зорилт 3.8 (85%): 38 яам, аймаг, нийслэлийн 2026 оны онцлох ажлыг дүгнэх журмын хэрэгжилтийн санхүүжилтийг шийдвэрлэж хоёрдугаар хагас жилд дүгнэлтийг хийх.


- Зорилт 10.2 (70%): ЗГХЭГ-ын удирдлагын шуурхай хуралдааны журмыг ЗЗБГ-тай хамтран хоёрдугаар хагас жилд батлуулах.
- Зорилт 11 (85%): Хууль тогтоомжийн давхардал, хийдлийн шинжилгээг дотоод системд суурилсан аргачлалаар хийх нотолгоо, баримтжуулалтыг сайжруулах.

ЗӨВЛӨМЖ

- Аудитын дүнг 2026.06.24-нд танилцуулж, хоёрдугаар хагас жилийн аудитын ажлыг Дотоод аудитын 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх.
- Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээг үлдсэн хагас жилийн хугацаанд эрчимжүүлэн ажиллах.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:



ДЭД ДАРГА С.БАТБОЛД

ЗАСГИЙН ГАЗРЫН РЕФЕРЕНТ
Б.ОРГИЛ

Хавсралт
Хүснэгт-3

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН /
ЗААЛТ БҮРИЙН ҮНЭЛГЭЭ/**

Арга хэмжээний д/д	Арга хэмжээний дугаар	Өөрсдийн өгсөн үнэлгээ	ХШҮ хийсэн үнэлгээ	Үнэлгээний тайлбар
Зорилт 1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны арга хэмжээний төлөвлөгөө"-г баталж, хэрэгжилтийг хангуулах				
1	1	100	100	Шалгуур: төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь (зорилтот 95%). 2026 оны арга хэмжааний төлөвлөгөөнд санал өгсөн. 2026 оны хэрэгжилт хангалттай явцтай. 100% үнэлэв.
2	1.1	100	100	Шалгуур: хугацаандаа тайлагнасан байх (02-02). ЗГХЭГ-т хамаарах 34 заалтын хэрэгжилтийг нэгтгэн АТГ-ын цахим системд тайлагнасан; хамааралгүй 14 заалтыг хяналтаас хасуулсан. Хугацаанд нь хийгдсэн.
3	1.2	100	100	Шалгуур: хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байх (02-02). АТГ-тай хамтран ТБ-уудын хөтөлбөрийн хэрэгжилтэд ХШҮ хийж цахим системд оруулсан. 100%.
4	1.3	100	100	Шалгуур: тайлан хугацаандаа хүргэгдсэн байх (02-02). 27 төрлийн нээлттэй мэдээллийг 40%—60% болгосон, Орон тооны бус зөвлөлд хугацаанд нь хүргэсэн. 100%.
Зорилтын үнэлгээ			100%	
Зорилт 2. Төрийн албаны шинэчлэлийн хүрээний байгууллагын гүйцэтгэлийн болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээний журмыг шинэчлэх				
5	2	30	75	Шалгуур: тоон утга (зорилтот 2). ТДД-ын 427 тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэн ажилласан. Журам шинэчлэлийн ажил эхэлсэн боловч удирдлагаас ЗГ-ын тухай, ЗГ дахь хяналтын тухай хуулиудад өөрчлөлт орох хүртэл хойшлуулсан. газраас гадуур шалтгаан. 75% үнэлэв.
6	2.1	50	85	Шалгуур: журмын төсөл боловсруулах (зорилтот 1). ЗГ-ын 2020 оны 217 тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах журмын төслийг боловсруулж удирдлагад танилцуулсан. Хойшлуулсан шалтгаан хуулийн шинэчлэлтэй холбоотой — газраас гадуур. 85% үнэлэв.
Зорилтын үнэлгээ			80%	
Зорилт 3. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайдын захирамж, албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд				

үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж арга зүйгаар хангах, үр дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулах

7	3	100	95	Шалгуур: хяналтаас хассан заалтын тоо (Т+), ЗГ-д хэлэлцүүлсэн тоо (2), хэрэгжилт өссөн хувь (Т%+). 1348 шийдвэрийн 5688 заалт, дундаж 73.98% — өмнөх оны мөн үетэй харьцуулахад +2.9%. ЗГ-ын 07, 15, 17, 18, 20 дугаар тэмдэглэлүүд гарсан. 95% үнэлэв.
8	3.1	100	100	Шалгуур: хяналтаас хассан заалт (Т+), ЗГ-д 2 удаа хэлэлцүүлэх (01-03). 2025 оны жилийн эцсийн ЗГ-ын шийдвэрийн биелэлтийг 2 сарын 25-ны 07-р хуралдаанаар хэлэлцүүлж, ЗГ-ын 144 тогтоол, 5 тэмдэглэлээр дахин хэлэлцүүлсэн — 6+ удаа, зорилтот 2-аас давсан. 100%.
9	3.2	100	100	Шалгуур: хяналтаас хассан заалт, ЗГ-д 2 удаа хэлэлцүүлэх (01-03). ЕС-ын 10 АД-ын 229 заалт, 19 захирамж, 27 шуурхай үүрэгт ХШҮ хийж ЗГ-д 5+ удаа танилцуулсан. 100%.
10	3.3	100	90	Шалгуур: сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо (зорилтот 100). МЕРИТ төслийн хүрээний ажлын хэсгийг мэдээллээр хангаж, бүсийн 5 аймагт сургалт зохион байгуулсан. 90% үнэлэв.
11	3.4	100	85	Шалгуур: арга хэмжээний тоо (зорилтот 1). ХШҮ-ний 30 жилийн ойн хүрээний ном товхимол гаргахаар МЕРИТ-тэй хамтарч, эрдэм шинжилгээний бага хурлыг 9-10 сард зохион байгуулахаар бэлтгэл хийж байна. Бэлтгэл ажил хийгдсэн. 85% үнэлэв.
12	3.5	100	90	Шалгуур: сургалт хийгдсэн байх (01-03). ЗГ-ын 183-р тогтоолын журмын дагуу мэдээллээр хангаж, 5 аймагт сургалт зохион байгуулсан. 3.3-тай нэгтгэн хийсэн тул 90% үнэлэв.
13	3.6	100	90	Шалгуур: хяналтаас хассан заалт (Т+), ЗГ-д 2 удаа хэлэлцүүлэх, хэрэгжилт өссөн (Т%). 1111 шийдвэрийн 3412 заалтыг хасах үндэслэлтэй гэж дүгнэсэн, Ажлын хэсэг байгуулж ажиллав. 2026.06.10-нд цахим сан нээгдсэн. 90% үнэлэв.
14	3.7	100	90	Шалгуур: зөвлөн тусалж ажилласан байх. 2025 оны нэгдсэн дүнгээр дүгнэлт, зөвлөмжийг ЗГ-ын хуралдаанаар танилцуулж холбогдох байгууллагуудад хүргэсэн. 90% үнэлэв.
15	3.8	100	85	Шалгуур: дүгнэх журам боловсруулах (1), байгууллагын тоо (38). 2026.03.25-ны 23 дугаар тушаалаар журам батлуулсан — 1/1=100%. Санхүүжилтийн улмаас 38 байгууллагыг дүгнэх ажил зогссон.

				Журам батлагдсаныг харгалзан 85% үнэлэв.
Зорилтын үнэлгээ			91.7%	
Зорилт 4. Иргэн, хуулийн этгээдээс Засгийн газар болон Ерөнхий сайдад хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг нэгтгэн, арга хэмжээний санал, шийдвэрийн төслийг боловсруулах				
16	4.1	100	100	Шалгуур: асуудал шийдвэрлэхтэй холбоотой баталсан шийдвэрийн тоо (суурь 4, зорилтот 4). ЗГ-ын 17-р хуралдааны 12.2-р тэмдэглэл гарсан. УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны 04.28-ны хуралдаанд танилцуулсан. Хагас жилийн жишиг хангасан. 100%.
Зорилтын үнэлгээ			100%	
Зорилт 5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээлэлд тулгуурлан технологийн дэвшлийг ашиглан мэдээллийг боловсруулж, бодлогын шийдвэр гаргалтад ашиглах				
17	5.1	100	85	Шалгуур-1: технологийн дэвшил ашигласан байдал, хувь (зорилтот 100%). Шалгуур-2: системийн хөгжүүлэлтийн явц (суурь 5%, зорилтот 10%). AI шинжилгаа хийсэн, аюулгүй байдлын хязгаарлалтаас дотоод системд хэрэглэсэн. 2026.06.10-нд цахим сан тайлан авахаар нээгдсэн. 1200 хэрэглэгчийг мэдээллээр хангасан. Хөгжүүлэлт зорилтод хүрсэн. 85% үнэлэв.
Зорилтын үнэлгээ			85%	
Зорилт 6. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээний тайланг нэгтгэж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх				
18	6.1	100	95	Шалгуур: ХШҮ хийсэн тоо (суурь 4, зорилтот 4). 2025 оны жилийн эцсийн биелэлтийг нэгтгэж, шуурхай үүрэг даалгаврын биелэлтэд 7 удаагийн шуурхай хуралд танилцуулсан. Дотоод системээр тайлан авч нэгтгэн ажилласан. Зорилтот 4-т хүрсэн. 95% үнэлэв.
19	6.2	100	80	Шалгуур: ХШҮ хийсэн тоо (суурь 2, зорилтот 3, 01-03). 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөрт ЗГХЭГ-ын 57 арга хэмжээний биелэлтийг 82.6% гэж системд байршуулсан; 43 тогтоолын журмын дагуу 42.5% — хоёр тайлан гарсан.
20	6.3	100	100	Шалгуур: ХШҮ хийсэн тоо (суурь 9, зорилтот 9). 11 нэгж болон 5 харьяа байгууллагын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд ХШҮ хийж даргад танилцуулсан. 16 байгууллага — зорилтот 9-аас давсан. 100%.
Зорилтын үнэлгээ			91.7%	

Зорилт 7. ЗГХЭГ-ын даргын төсвийн багцын байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, удирдлагыг мэдээллээр хангах				
21	7.1	70	80	Шалгуур: хяналт шалгалт хийсэн байгууллагын тоо (суурь 4, зорилтот 3), илрүүлсэн зөрчлийн тоо. ЗГБНҮГ-ын 2025 оны санхүүгийн аудит: 1,307.6 сая ₮-ийн 10 зөрчил, 8 дүгнэлт, 6 зөвлөмж — 2026.05.29-нд танилцуулсан. МУШС-ын аудитыг эхэлж, 2026.06.24-нд дүн танилцуулахаар болсон. Хагас жилийн жишиг 1.5-д хүрсэн. 80% үнэлэв.
22	7.2	100	90	Шалгуур: холбогдох хууль тогтоомжийн хүрээний гүйцэтгэл. ЗГ-ын хуралдааны журмын хяналт шалгалт: 72.5% хэрэгжилт, 4 дүгнэлт, 11 зөвлөмж гаргасан. МУШС-ын аудит эхэлсэн. 90% үнэлэв.
Зорилтын үнэлгээ			85%	
Зорилт 8. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллага, төрийн өмчийн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх				
23	8.3	100	85	Шалгуур: зөвлөмжийн хэрэгжилтийн хувь (суурь 85%, зорилтот 88%). тухай бүр үүрэг даалгавар хүргүүлж, ажлын төлөвлөгөөг ҮАГ-г хүргүүлсэн. ҮАГ-аас ирсэн 4 тайлантай танилцаж, шийдвэрийн хэрэгжилтийн хяналтыг хангав. Бодит хэрэгжилтийн хувь 85% үнэлэв.
Зорилтын үнэлгээ			85%	
Зорилт 9. ЗГ-ын тогтоол, ЕС-ын захирамж, сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгүүдийг уялдаа, удирдлага зохицуулалтаар хангаж, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх				
24	9.1	100	90	Шалгуур: удирдамжийн дагуу хийгдсэн байх. 2023-2026 оны санхүүгийн аудит хийж 1,062.1 сая ₮-ийн 17 зөрчил илрүүлж 6 дүгнэлт, 6 зөвлөмж гаргасан. Хархорум хот: 518.7 сая ₮-ийн 6 зөрчил, 8 дүгнэлт, 8 санал. 90% үнэлэв.
Зорилтын үнэлгээ			90%	
Зорилт 10. ЗГХЭГ-ын даргын шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг холбогдох хугацаанд тухай бүр тайлагнаж удирдлагад танилцуулах				
25	10.1	100	100	Шалгуур: тайлагналтын тоо (суурь 12, зорилтот 6), хугацаанд тайлагнасан эзлэх хувь 70%+. 7 удаагийн шуурхай хуралд танилцуулсан — зорилтот 3 (50%)-аас давсан. Биелэлтийн дундаж 70%→88% болсон. 100%.
26	10.2	100	70	Шалгуур: журам батлагдсан байх (зорилтот 1). Журмын төслийг боловсруулж ЗЗБГ-г хүргүүлсэн боловч батлагдсан баримт байхгүй. Бэлтгэл ажил хийгдсэнийг харгалзан 70% үнэлэв.
Зорилтын үнэлгээ			85%	

Зорилт 11. ЗГ-ын тогтоол, шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, Засгийн газрын шийдвэрийн төсөлд хууль зүйн мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх				
27	11	100	85	Шалгуур: шийдвэрийн давхардал, хийдэл, зөрчилтэй заалтыг бууруулсан хувь (зорилтот Т-50%). УИХ-ын тогтоол, байнгын хорооны шийдвэрт АI ашиглан бодлогын давхардал, эрх зүйн илүүдлийг шинжилсэн. Аюулгүй байдлын шалтгаанаар гадаад АI системд хийхгүй болсон — газрын хяналтаас гадуурх шалтгаан. Бодитой шинжилгээ хийгдсэн ч буурсан %- тодорхой бус. 85% үнэлэв.
Зорилтын үнэлгээ			85%	
Зорилт 12. Иргэн, хуулийн этгээд, төрийн бусад байгууллагаас Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын удирдлагад хандаж ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг судалж, хуульд заасан хугацаанд хариу өгч, шийдвэрлэх				
28	12.1	100	90	Шалгуур: хугацаанд нь шийдвэрлэсэн хувь 100% (суурь 208 бичиг, 109 өргөдөл). Нийт 126 өргөдөл, гомдол хүлээж авснаас 81 шилжүүлсэн, 33 утсаар, 6 бусад, 6 хянагдаж байгаа. 4 иргэнийг Ерөнхий сайдын зөвлөхтэй уулзуулсан. 6 гомдол хянагдаж байгаа тул 90% үнэлэв.
Зорилтын үнэлгээ			90%	
Нийт дундаж үнэлгээ		93.8%	89%	Бууруулсан зорилтууд: Зорилт 2 (80%) — журам шинэчлэл хойшилсон; Зорилт 3.4 (85%), 3.8 (85%) — ойн арга хэмжээ болон дүгнэлт хийгдээгүй; Зорилт 5 (85%) — системийн хөгжүүлэлт үргэлжилж байна; Зорилт 7.1 (80%) — 2 аудит хийгдсэн боловч дүн бүрэн гараагүй; Зорилт 10.2 (70%) — журам батлагдаагүй; Зорилт 11 (85%) — АI шинжилгээний бүрэн бус биелэлт.